



Байнгын хорооны 2022 оны 15  
дугаар тогтоолын нэгдүгээр  
хавсралт

## СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

**Товч удирдамж:** Нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн доор /ард/ хариултаа үнэн зөв бичнэ. Компьютерын програм ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралт мөн Word-ын файлыг цахим шуудангаар тус тус Байнгын хороонд явуулна.

### НЭГ. НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, НИЙТЛЭГ ШААРДЛАГА

1.1	<b>Эцэг/эхийн нэр:</b> Доржсүрэн <b>Ургийн овог:</b> Буж <b>Нэр:</b> Мөнхзориг <b>Хүйс:</b> Эр <b>Төрсөн он:</b> 1980 <b>Төрсөн газар:</b> Өвөрхангай аймгийн Арвайхээр сум <b>Иргэний харьяалал:</b> Монгол <b>Одоо оршин суугаа аймаг/нийслэл, сум/дүүрэг:</b> Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 19-р хороо, Туулын хөвөө хотхон, 36-р байр, 45 тоот /Мэдээлэл гаргагчийн зөвшөөрлөөр/
1.2	<b>Нэр дэвших тухай хүсэлт гаргаж буй албан тушаал</b> Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн
1.3	<b>Иргэний харьяалал</b> Монгол Улсын иргэн мөн эсэх: Тийм Монгол Улсаас өөр улсын иргэний харьяалалтай байсан эсэх: Үгүй
1.4	<b>Боловсрол</b> Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн он дарааллаар жагсааж, холбогдох нотлох баримтыг хавсаргана. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ. 2019-2021 онд Түшээ дээд сургууль, Магистр, Эрх зүйч 2014-2016 онд Удирдлагын академи, Төрийн захиргааны менежер 2011-2015 онд Түшээ дээд сургууль, Бакалавр, Эрх зүйч 1998-2003 онд ШУТИС-КТМС, Бакалавр, Компьютерын техник хангамжийн инженер
1.5	<b>Эрхэлсэн ажил</b> Их, дээд сургууль төгссөнөөс хойш эрхэлсэн ажлыг тодорхойлон бичнэ. Ажилласан байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар жагсаах бөгөөд ажил олгогч

	<p>/эсхүл, удирдах албан тушаалтан/-ийн нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>- 2022 оноос Шүүхийн сахилгын хорооны Ажлын албаны дарга</li> <li>- 2019-2022 онд Төв аймаг дахь шүүхийн Тамгын газрын дарга</li> <li>- 2010-2019 онд Шүүхийн ерөнхий зөвлөлийн Мэдээллийн технологийн асуудал хариуцсан референт (2010-2012), Мэдээллийн технологийн тасгийн дарга (2012-2013), Мэдээллийн технологийн хэлтсийн дарга (2013-2019)</li> <li>- 2003-2007 онд Улсын дээд шүүхийн Компьютерын техник хангамж хариуцсан шинжээч (2003-2005), Компьютерын техник хангамж хариуцсан референт (2005-2007)</li> </ul>
1.6	<p><b>Улс төрийн болон намын удирдах, гүйцэтгэх албан тушаал</b> Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байсан эсэхийг бичих. /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл эрхэлж байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>Үгүй</p>
1.7	<p><b>Эрүүгийн хариуцлага</b> Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах/</p> <p>Үгүй</p>
1.8	<p><b>Яллагдагчаар татагдсан эсэх</b> Яллагдагчаар татагдсан эсэх /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол товч тайлбарыг бичих/.</p> <p>Үгүй</p>
1.9	<p><b>Сахилгын шийтгэлийн талаар</b> Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж эсхүл огцорч байсан эсэх /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>Үгүй</p>
1.10	<p><b>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар</b></p> <p>-Төрийн бус байгууллагад эрхэлж байсан албан тушаал, гүйцэтгэсэн чиг үүрэг, огноог хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичнэ.</p> <p>.....</p> <p>.....</p>
1.11	<p><b>Нэр дэвшигч нь хэрэв байгаа бол доор дурдсан мэдээллийг бичнэ</b></p> <p>-Өөрийн боловсруулсан, хянасан судалгааны ажил, ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.</p> <p>-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.</p> <p>-сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.</p> <p>-сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.</p> <p><b>Жич:</b> Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх линкийг тусгана.</p>

**Шүүхийн сахилгын хорооноос гаргасан доорх ном бүтээлүүдийг хянан тохиолдуулж ажилласан:**

1. Шүүхийн сахилгын хорооны үйл ажиллагааны тайлан /Мөнхийн үсэг, 2022-2025/
2. Монгол Улсын шүүхийн шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн шийдвэрийн эмхэтгэл /Би Си Ай ХХК, 2025/
3. Монгол Улсын шүүхийн сахилгын хорооны Түүхэн хөгжил ном /Мөнхийн үсэг, 2023/

**Шүүхийн сахилгын хорооноос баталсан доорх журмын төсөл боловсруулж ажилласан:**

1. Ажлын албаны дүрэм, зохион байгуулалтын бүтэц, төрийн захиргааны албан тушаалын орон тоог шинэчлэн батлах тухай
2. Шүүхийн сахилгын хорооны бэлгэ тэмдгийн загвар, зураглалын журам
3. Хөдөлмөрийн дотоод журам
4. Архив, албан хэрэг хөтлөлтийн журам
5. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний зөрчлийн талаарх өргөдөл, мэдээлэл хянан шийдвэрлэх журам
6. Шүүхийн сахилгын хорооны ажлын албаны ажилтны ёс зүйн дүрэм
7. Шүүхийн сахилгын хорооны төрийн болон албаны нууц хамгаалах журам
8. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах журам
9. Шүүхийн сахилгын хорооны сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн үйл ажиллагааны статистикийн нэгдсэн мэдээлэл, тайлан гаргах маягтын загвар, “Маягтад заасан тоон мэдээллийг гарга аргачлал”
10. Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дэлгэрэнгүй тайлангийн маягт

**Хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг:**

1. Үндэсний хэмжээний шүүхийн захиргааны ажилтнуудын чуулганд “Шүүхийн захиргааны өнөөгийн байдал, цаашдын хандлага” сэдвээр” хэлэлцсэн.

[https://judcouncil.mn/site/news\\_full/13340?fbclid=IwAR31kPROQ1FXNP0cLuGheEBAs-GXTbnMIOdYXT5sNvYwVCqjtRWX85CP1-k](https://judcouncil.mn/site/news_full/13340?fbclid=IwAR31kPROQ1FXNP0cLuGheEBAs-GXTbnMIOdYXT5sNvYwVCqjtRWX85CP1-k)

2. Шүүхийн сахилгын хорооны гишүүд, Европын холбооны гишүүн орнуудын мэргэжилтнүүдтэй хийсэн хэлэлцүүлэгт “Шүүхийн сахилгын хорооны цахимжилт” сэдвээр илтгэл тавьсан.

<https://judiscom.mn/site/single/347>

**Хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэл:**

1. Зууны мэдээ Үндэсний өдөр тутмын сонин /2026.04.13/. Д.Мөнхзориг: Сахилгын хороо зөвхөн хариуцлага тооцдог бус шүүгчдийнхээ нэр хүндийг хамгаалж ажилладаг. Линк: <https://www.zms.mn/a/103942>

2. [#MongolTV](#) [#ORI](#) [#TerminalUB](#)

Өнөөдрийн дугаарт Хууль зүйн ухааны доктор Д.Батболд, Шүүхийн сахилгын хорооны Ажлын албаны дарга Д.Мөнхзориг нар оролцлоо /2024.11.06/

<https://www.youtube.com/watch?v=1suRa7r7nAw>

3. Шүүхийн Сахилгын хорооноос хийсэн хэвлэлийн хурал /2022.07.05/ Д.Мөнхзориг: Хуулийн дагуу 28 шүүгчид сахилгын шийтгэл оногдуулсан Линк: <https://www.shuud.mn/a/541633>

## ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

2.1	<p>Тухайн албан тушаалд томилогдвол хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /500-1000 үгэнд багтаана/.</p> <p>Сонгуулийн ерөнхий хороо нь Монгол Улсын Улсын Их Хурлын болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль, ард нийтийн санал асуулга, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийг улс орон даяар удирдан зохион байгуулж явуулах бүрэн эрхтэй онцлогтой чухал байгууллага юм.</p> <p>Миний бие ардчилсан үндсэн хуульт ёсны гурван тулгуур эрх мэдлийн нэг “ШҮҮХ” засаглалын бүтцийн байгууллагууд болох Шүүхийн ерөнхий зөвлөлийн Мэдээллийн технологийн хэлтсийн дарга, аймгийн шүүхийн тамгын газрын дарга, Шүүхийн сахилгын хорооны Ажлын албаны дарга зэрэг төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдон ажиллах хугацаандаа хууль дээдлэх ёсыг хангах, төрийн албаны сахилга бат, ёс зүйг чанд сахиулах, процессын үйл ажиллагааг хуулийн дагуу үнэн зөв удирдан зохион байгуулах чиглэлээр мэргэшсэн, ажлын туршлага хуримтлуулсан. Ингэхдээ ялангуяа төрийн байгууллага, албан хаагчийн ажлын бүтээмж, үйл ажиллагааг хөнгөвчлөхөд чиглэсэн мэдээллийн технологийн ололт, үр нөлөөг нэвтрүүлэх, цаашлаад түүнийг тогтмол ашиглах, хөгжүүлэхэд манлайлан гар бие оролцож, тодорхой үр дүнд хүргэсэн байна.</p> <p>Тиймээс миний бие өөрийн мэдлэг, боловсрол, ажлын туршлагадаа үндэслэн сонгуулийн үйл ажиллагааг хуулийн дагуу шударга, маргаангүй, ил тод, нээлттэй зохион байгуулах чиг үүрэг бүхий энэхүү байгууллагын гишүүний албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан тул нэрээ дэвшүүлсэн болно.</p> <p>СЕХ-ны гишүүнээс хууль дээдлэх зарчим, улс төрийн нөлөөллөөс бүрэн ангид байх хараат бус байдал, шударга ёсны өндөр мэдрэмжийг шаарддаг гэж ойлгодог. Хэрэв миний бие СЕХ-ны гишүүнээр томилогдвол Монгол Улсын Үндсэн хууль, Сонгуулийн төв байгууллагын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг чанд мөрдөж, дараах чиглэлээр хариуцлагатай, идэвх санаачилгатай ажиллах болно.</p> <p>Үүнд:</p> <ol style="list-style-type: none"><li>1. Сонгуулийн ирцийг нэмэгдүүлэх, залуучуудын оролцоог идэвхжүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлд мэдээллийн технологийн ололтыг ашиглах: Сүүлийн жилүүдэд сонгуулийн ирц, тэр дундаа залуу үеийн оролцоо буурах хандлагатай байгаа нь ардчиллын төлөөллийн зарчимд сөрөг нөлөөтэй юм. Тухайлбал, 2024 оны сонгууль өгөх насны 2,238,360 иргэний 355,533 иргэн буюу 15.8 хувь нь 18-25 насныхан эзэлж байна. Иймд залуучуудын сонирхол, харилцааны онцлогт тохирсон дижитал цахим шилжилтийг сонгогчийн боловсролын хөтөлбөрт нэвтрүүлнэ. Ухаалаг утасны аппликейшн, сошиал медиа сувгуудыг ашиглан сонгуулийн ач холбогдлыг таниулах хялбаршуулсан контентуудыг цувралаар хүргэх. Түүнчлэн, их дээд сургуулиуд болон оюутны хотхон, оюутны холбоо зэрэг эрх зүйн этгээдтэй хамтран ажиллаж, залуучуудын шилжилт хөдөлгөөн, бүртгэлийн процессыг цахимжуулан хялбарчлах замаар санал өгөх боломжийг практик талаас нь судлан улсын бүртгэлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэхэд анхаарч ажиллана. ЕБС-ийн ахлах ангиас эхлэн сонгогчийн боловсрол олгох хөтөлбөрийг салбарын яамтай хамтран өргөжүүлнэ.</li><li>2. Сонгогч чөлөөтэй, хүсэл зоригоороо санал өгөх нөхцөлийг бүрдүүлэх: Сонгогч бүр гадны ямар нэгэн дарамт, шахалт, эдийн засаг болон улс төрийн нөлөөллөөс ангид, зөвхөн өөрийн үзэл бодлоор саналаа өгөх нь сонгуулийн үндсэн зарчим байдаг. Энэ хүрээнд хууль бус санал худалдан авах үйлдлийг таслан зогсоох, ийм нөхцөл байдлыг гаргуулахгүй байхын тулд хууль хяналтын байгууллагатай хамтран ажиллах, хариуцлагатай, шуурхай шийдвэрлэдэг байдлыг бүрдүүлнэ.</li><li>Мөн санал өгөх байрны зохион байгуулалт, санал өгөх байршлыг хүртээмжтэй зохион байгуулах, саналын нууцлалыг хангахад анхаарч ажиллана. Үүний зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настан, алслагдсан бүсийн иргэдийн санал өгөх эрхийг тэгш хангах дэд бүтэц, хүртээмжийг сайжруулахад мэдээллийн технологийн ололтыг ашиглахад санал санаачилгатай, үр бүтээлтэй ажиллана гэж бодож байна.</li><li>3. Сонгуулийн байгууллагын хариуцлага, ёс зүйг дээшлүүлж, маргааныг шуурхай шийдвэрлэх:</li></ol>
-----	---

Миний бие ажлын туршлагадаа үндэслэн СЕХ болон доод шатны сонгуулийн хороодын гишүүдийн ёс зүй, хариуцлагыг чангатгахад анхаарна. Сонгуулийн зохион байгуулалтад оролцож буй төрийн албан хаагчдыг улс төрийн нөлөөнд автахаас сэргийлж, зөвхөн хуулийн дагуу ажиллах мэргэшсэн байдлыг хангана. Ялангуяа төрийн албанд шинээр орсон албан хаагчийг ажиллуулах байдлыг нэмэгдүүлнэ. Сонгуулийн явцад болон дараа нь гарсан гомдол, маргааныг хуулийн хугацаанд, нээлттэй, ямар нэгэн намын харьяалал харахгүйгээр, нөлөөлөлгүйгээр, шуурхай шийдвэрлэдэг процессын тодорхой хэм хэмжээг ойлгомжтой, тодорхой, хоёрдмол утгагүй, боловсронгуй болоход анхаарч ажиллана. Аливаа асуудлыг шийдвэрлэдэг үе шат болгоныг хугацаатай холбох, түүнд чиглэсэн цахим шийдвэрлэлтийг нэвтрүүлэх асуудлыг судалж, ажил хэрэг болгоно.

4. Технологийн аюулгүй байдал, итгэлцлийг бэхжүүлэх:

Санал тоолох төхөөрөмжийн ажиллагаа, дүн дамжуулах сүлжээний цахим аюулгүй байдлыг системийн хувьд анхаарч, шаардлагатай бол боловсронгуй болгоно. Хяналтын гар тооллогыг хуулийн дагуу ил тод, эргэлзээгүй зохион байгуулах нь сонгуулийн дүнд итгэх иргэдийн итгэлийг хамгаалагддаг учир үүнд мөн анхаарч ажиллана.

**Хавсралт:**

*Холбогдох хуульд заасан шаардлагыг хангасныг нотлох дараах болон бусад баримт бичгийг нэр дэвших тухай хүсэлтэд хавсаргана:*

- төрийн албан хаагчийн анкет;
- эрх бүхий байгууллагаас нэр дэвшүүлсэн албан бичиг, шийдвэр;
- иргэний үнэмлэхийн хуулбар;
- нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг;
- боловсролын зэргийн дипломын хуулбар;
- хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг;
- тухайн албан тушаалыг хашихад шаардлагатай түвшний мэдлэг, чадвар, туршлага, ёс зүйтэй гэдгийг нотлон харуулсан 10-аас доошгүй тодорхой үйл ажиллагааны талаарх баримт;
- энэхүү загварт заасан баримт бичиг;
- холбогдох бусад баримт.

**Хүсэлт гаргагч:**

Эцэг/эхийн нэр: Доржсүрэн

Өөрийн нэр: Мөнхзориг

Гарын үсэг:

Он, сар, өдөр: